



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/102

Алтрага

Сонгон шалгаруулах үнэлгээний хороо  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих "Багт монгол гэртэй болох" 5,000,000 (таван сая) төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Л.Чимэдцэрэн (Засаг даргын орлогч)
Гишүүд:	Т.Батбямба (Байгаль хамгаалагч)
Нарийн бичгийн дарга:	З.Наранцэцэг (Төсөв төрийн сангийн мэргэжилтэн)

2.2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих "Багт монгол гэртэй болох" ажлыг хууль журмын хүрээнд зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Л.Чимэдцэрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010235